



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хот

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.8, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30.1, 30.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хязгаар шинэчлэн тогтоох тухай А/847 дугаар захирамж, 2024 оны “Эрх шилжүүлэх тухай” А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/244 дүгээр захирамж, 2025 оны “Захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/357 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2026 оны 04 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох хуулийн этгээдийг нэгдүгээр, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 6 хуулийн этгээдийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Номин)-, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Т.Баатар)-т, дүүргийн 1-24 дүгээр хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бичилт, олголт, хураамжид байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Э.Энхсүвд)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ